**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ**

# Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код**: ГАА-2025/041/НА-СТА-ТШЗ

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг:tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Л.Отгон
Утас: 99059489 Цахим хаяг: devjikhcapital.audit@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2025 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02. 24 № 86

танай ____________ -ны № ____________ -т

ХӨХМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б. БАТБААТАР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.4, 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Шилэн дансны тухай хуулийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 дэх заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Цахим дэлгүүрээс 17,801.8 мянган төгрөгийн компьютер, тоног төхөөрөмжийг худалдан авалт хийгээгүй.
- Засаг даргын нөөц хөрөнгөнөөс сумын аварга малчин, алдарт уяачдын шагнал, бэлэг дурсгалын зүйлд 17,361.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

8225020314

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд сумын 100 жилийн ой тохиож аймгийн төсвөөс 100,000.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосноос 85,329.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэжээ.

Иргэд, байгууллагаас 44,860.0 мянган төгрөгийн хөрөнгийг хандиваар хүлээн авч бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

"Нээлттэй Алтай" хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар шинээр гэр бүл болсон 14 залуу малчин өрхөд тус бүр 50 толгой бог мал олгож, малжуулах ажлыг зохион байгуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 10 зорилт 76 арга хэмжээний хэрэгжилт 94.4 хувьтай үнэлэгдсэн байна.
Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **182,528,660.00** | **127,053,660.00** |
| **33** | **АВЛАГА** | **59,000,000.00** | **3,000,000.00** |
| **33500** | **Бусад авлага** | **59,000,000.00** | **3,000,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 56,000,000.00 | - |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **123,528,660.00** | **124,053,660.00** |
| **35400** | **Хангамжийн материал** | **15,298,660.00** | **15,823,660.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 800,000.00 | 335,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,128,360.00 | 2,868,360.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,370,300.00 | 12,620,300.00 |
| 35600 | Мал амьтад | 108,230,000.00 | 108,230,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **925,312,158.28** | **1,601,777,183.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **925,312,158.28** | **1,601,777,183.79** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **924,240,158.28** | **1,600,705,183.79** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 976,564,047.73 | 1,591,321,822.73 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (431,259,640.78) | (500,669,597.15) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 81,361,583.00 | 84,361,583.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (52,231,157.86) | (62,759,803.62) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 353,670,907.00 | 411,456,007.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (154,950,941.87) | (203,265,272.16) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 166,547,998.00 | 305,610,198.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (62,307,741.15) | (66,901,108.26) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 9,430,000.00 | 9,430,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 42,350,000.00 | 42,350,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,734,895.79) | (11,028,645.75) |
| 39217 | Ном | 800,000.00 | 800,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,072,000.00** | **1,072,000.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,072,000.00 | 1,072,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,107,840,818.28** | **1,728,830,843.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5,141,174.00** | - |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **5,141,174.00** | - |
| **41300** | **Өглөг** | **5,141,174.00** | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 5,141,174.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,102,699,644.28** | **1,728,830,843.79** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,102,699,644.28** | **1,728,830,843.79** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 515,312,046.00 | 515,312,046.00 |
| 511002 | Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө | 515,312,046.00 | 515,312,046.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **29,431,710.65** | **655,562,910.16** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (90,446,867.82) | 29,431,710.65 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 119,878,578.47 | 626,131,199.51 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 557,955,887.63 | 557,955,887.63 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,107,840,818.28** | **1,728,830,843.79** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **985,791,576.00** | **1,802,882,253.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **181,428,998.00** | **740,847,775.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **181,428,998.00** | **740,847,775.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 178,823,698.00 | 740,597,775.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 2,500,300.00 | 250,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **804,362,578.00** | **1,062,034,478.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **116,886,378.00** | **161,161,578.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 116,886,378.00 | 160,179,578.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 482,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **687,476,200.00** | **900,872,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 687,476,200.00 | 900,872,900.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **840,294,048.39** | **1,175,775,744.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **840,294,048.39** | **1,175,775,744.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **819,989,432.34** | **1,100,709,036.79** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **394,798,700.74** | **631,327,914.32** |
| 210101 | Үндсэн цалин | 207,646,718.08 | 285,210,870.72 |
| 210102 | Нэмэгдэл | 137,890,181.17 | 296,686,637.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,095,000.00 | 46,366,405.94 |
| 210104 | Урамшуулал | 11,271,962.00 | 3,064,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **49,343,069.32** | **85,271,900.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,702,483.05 | 62,751,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,169,384.58 | 5,630,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,535,507.95 | 2,815,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 630,517.67 | 2,815,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,305,176.07 | 11,260,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **38,573,061.49** | **39,107,547.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,485,313.49 | 2,241,564.33 |
| 210302 | Түлш, халаалт | 35,874,748.00 | 36,865,983.25 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **37,588,905.00** | **33,209,013.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,639,080.00 | 5,944,850.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,520,700.00 | 20,460,113.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,448,700.00 | 2,359,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 60,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,980,425.00 | 4,385,050.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,973,800.00** | **18,990,620.00** |
| 210604 | Урсгал засвар | 19,973,800.00 | 18,990,620.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **20,400,000.00** | **13,771,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,400,000.00 | 13,771,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,543,245.40** | **23,941,331.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,972,600.00 | 23,237,891.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 50,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 57,088.00 | 130,176.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 54,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,422,074.40 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,033.00 | 29,264.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **220,273,650.39** | **255,089,210.89** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 89,744,104.00 | 84,686,670.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,999,500.00 | 1,920,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 128,530,046.39 | 168,482,540.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,304,616.05** | **75,066,708.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **19,075,000.00** | **32,938,007.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,000,000.00 | 30,638,007.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,075,000.00 | 2,300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **1,229,616.05** | **42,128,701.10** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,107,616.45 | 2,054,842.10 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 121,999.60 | 40,073,859.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **145,497,527.61** | **627,106,508.11** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **25,618,949.14** | **975,308.60** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 25,618,949.14 | 975,308.60 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **119,878,578.47** | **626,131,199.51** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **804,467,578.00** | **1,118,034,478.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **804,467,578.00** | **1,118,034,478.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **116,991,378.00** | **217,161,578.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 116,886,378.00 | 216,179,578.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 105,000.00 | 482,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **687,476,200.00** | **900,872,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 687,476,200.00 | 900,872,900.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **760,785,578.00** | **1,012,709,378.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **760,785,578.00** | **1,012,709,378.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **681,480,961.95** | **937,642,669.90** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **394,798,700.74** | **631,327,914.32** |
| 210101 | Үндсэн цалин | 207,646,718.08 | 285,210,870.72 |
| 210102 | Нэмэгдэл | 137,890,181.17 | 296,686,637.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 24,095,000.00 | 46,366,405.94 |
| 210104 | Урамшуулал | 11,271,962.00 | 3,064,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **49,343,069.32** | **85,271,900.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,702,483.05 | 62,751,900.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,169,384.58 | 5,630,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,535,507.95 | 2,815,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 630,517.67 | 2,815,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,305,176.07 | 11,260,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **27,931,887.49** | **44,248,721.58** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,485,313.49 | 2,241,564.33 |
| 210302 | Түлш, халаалт | 25,233,574.00 | 42,007,157.25 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **38,251,655.00** | **32,744,013.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,301,830.00 | 5,479,850.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,520,700.00 | 20,460,113.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,448,700.00 | 2,359,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 60,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,980,425.00 | 4,385,050.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **19,973,800.00** | **18,990,620.00** |
| 210604 | Урсгал засвар | 19,973,800.00 | 18,990,620.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **20,400,000.00** | **13,771,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,400,000.00 | 13,771,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **36,543,245.40** | **23,941,331.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 34,972,600.00 | 23,237,891.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 54,450.00 | 50,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 57,088.00 | 130,176.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 54,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,422,074.40 | 440,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,033.00 | 29,264.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **91,743,604.00** | **87,346,670.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 89,744,104.00 | 85,426,670.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,999,500.00 | 1,920,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **79,304,616.05** | **75,066,708.10** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **22,075,000.00** | **32,938,007.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 12,000,000.00 | 30,638,007.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 10,075,000.00 | 2,300,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **57,229,616.05** | **42,128,701.10** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,107,616.45 | 2,054,842.10 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 56,121,999.60 | 40,073,859.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **43,682,000.00** | **105,325,100.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **43,682,000.00** | **105,325,100.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **43,682,000.00** | **105,325,100.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **43,682,000.00** | **105,325,100.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 43,682,000.00 | 105,325,100.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(43,682,000.00)** | **(105,325,100.00)** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **515,312,046.00** | **557,955,887.63** | **(90,446,867.82)** | **982,821,065.81** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 515,312,046.00 | 557,955,887.63 | (90,446,867.82) | 982,821,065.81 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | - | - | 119,878,578.47 | 119,878,578.47 |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **515,312,046.00** | **557,955,887.63** | **29,431,710.65** | **1,102,699,644.28** |
| **11** | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **515,312,046.00** | **557,955,887.63** | **29,431,710.65** | **1,102,699,644.28** |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 515,312,046.00 | 557,955,887.63 | 29,431,710.65 | 1,102,699,644.28 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 626,131,199.51 | 626,131,199.51 |
| **20** | **2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **515,312,046.00** | **557,955,887.63** | **655,562,910.16** | **1,728,830,843.79** |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Гүйцэтгэл зөрүү | Биелэлт Хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **900,872,900.00** | **898,818,057.90** | **2,054,842.10** | **99.77** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **900,872,900.00** | **898,818,057.90** | **2,054,842.10** | **99.77** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **867,930,900.00** | **865,880,050.90** | **2,050,849.10** | **99.76** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **631,373,700.00** | **631,327,914.32** | **45,785.68** | **99.99** |
| 210101 | Үндсэн цалин | 207,373,700.00 | 285,210,870.72 | (77,837,170.72) | 137.53 |
| 210102 | Нэмэгдэл | 424,000,000.00 | 296,686,637.66 | 127,313,362.34 | 69.97 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **85,275,000.00** | **85,271,900.00** | **3,100.00** | **100.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,755,000.00 | 62,751,900.00 | 3,100.00 | 100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,630,000.00 | 5,630,000.00 | - | 100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,815,000.00 | 2,815,000.00 | - | 100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,815,000.00 | 2,815,000.00 | - | 100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,260,000.00 | 11,260,000.00 | - | 100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **44,523,700.00** | **44,248,721.58** | **274,978.42** | **99.38** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,500,000.00 | 2,241,564.33 | 258,435.67 | 89.66 |
| 210302 | Түлш, халаалт | 42,023,700.00 | 42,007,157.25 | 16,542.75 | 99.96 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **30,706,500.00** | **30,582,435.00** | 124,065.00 | 99.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,462,500.00 | 5,479,850.00 | (17,350.00) | 100.32 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,350,000.00 | 18,298,535.00 | 51,465.00 | 99.72 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,400,000.00 | 2,359,000.00 | 41,000.00 | 98.29 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | 60,000.00 | 40,000.00 | 60.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,394,000.00 | 4,385,050.00 | 8,950.00 | 99.80 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **38,000,000.00** | **37,986,720.00** | **13,280.00** | **99.97** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,000,000.00 | 18,996,100.00 | 3,900.00 | 99.98 |
| 210604 | Урсгал засвар | 19,000,000.00 | 18,990,620.00 | 9,380.00 | 99.95 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **13,772,000.00** | **13,771,500.00** | **500.00** | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 13,772,000.00 | 13,771,500.00 | 500.00 | 100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **780,000.00** | **703,440.00** | **76,560.00** | **90.18** |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 60,000.00 | 50,000.00 | 10,000.00 | 83.33 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 130,176.00 | 19,824.00 | 86.78 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 90,000.00 | 54,000.00 | 36,000.00 | 60.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 440,000.00 | 10,000.00 | 97.78 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210807 | Газрын төлбөр | 30,000.00 | 29,264.00 | 736.00 | 97.55 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **23,500,000.00** | **21,987,420.00** | **1,512,580.00** | **93.56** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,500,000.00 | 20,067,420.00 | 1,432,580.00 | 93.34 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,000,000.00 | 1,920,000.00 | 80,000.00 | 96.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **32,942,000.00** | **32,938,007.00** | **3,993.00** | **99.99** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **32,942,000.00** | **32,938,007.00** | **3,993.00** | **99.99** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 30,642,000.00 | 30,638,007.00 | 3,993.00 | 99.99 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,300,000.00 | 2,300,000.00 | - | 100.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **900,872,900.00** | **898,818,057.90** | **2,054,842.10** | **99.77** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **900,872,900.00** | **898,818,057.90** | **2,054,842.10** | **99.77** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 900,872,900.00 | 898,818,057.90 | 2,054,842.10 | 99.77 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **26** | **22** | **-** | 84.62 |
| 620001 | Удирдах ажилтан | 9 | 9 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 12 | 8 | - | 66.67 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5 | 5 | - | 100.00 |

## 2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **117,903,452.40** | **217,161,578.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **117,903,452.40** | **217,161,578.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 61,781,452.80 | 177,087,719.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,032,000.00 | 2,161,578.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,032,000.00 | 2,161,578.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 34,798,798.80 | 23,237,891.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 33,886,724.40 | 23,237,891.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 912,074.40 | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,950,654.00 | 151,688,250.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,950,654.00 | 151,688,250.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 56,121,999.60 | 40,073,859.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **56,121,999.60** | **40,073,859.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 56,121,999.60 | 40,073,859.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **116,991,378.00** | **161,161,578.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **116,991,378.00** | **161,161,578.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 116,886,378.00 | 160,179,578.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 105,000.00 | 982,000.00 |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар 118,464.0 мянган төгрөгийн алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**
- Нэмэлт санхүүжилтийн орлого 56,982.0 мянган төгрөгийг үндсэн дансны орлогоор тайлагнасан.
- Нэмэлт санхүүжилтийн төсвийн хэлбэлзэл 4,482.0 мянган төгрөгөөр зөрүүтэй.
- Мөнгөн гүйлгээний тайланд 1,000.0 мянган төгрөгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан самбарыг биет ба биет бус хөрөнгө худалдан авснаар тайлагнаагүй байна.
- Татаас санхүүжилтийн авлага 56,000.0 мянган төгрөг барагдуулсан байхад үр дүнгийн тайланд орлогоор бүртгэж, авлагын тайланд авлагын үлдэгдэлтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 35,162.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 35,162.8 мянган төгрөгийн 3 зөрчил[2] илэрч зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

**Албан шаардлага**

1. Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 17,361.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авч бэлэглэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-т төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно гэж заасантай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант онд 17,801.8 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй , эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Цахим дэлгүүрээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Шилэн дансанд таван саяас дээш 1,094,679.2 мянган төгрөгийн 23 орлогын гүйлгээ, нийт 262,030.4 мянган төгрөгийн 20 гүйлгээнээс 148,718.9 мянган төгрөгийн 9 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй , эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг зөрчсөн байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үгүйд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Шийдвэрлэлт: Шилэн дансны цахим системд мэдээллийг цаг хугацаанд оруулах албан шаардлага хүргүүлсэн.

## Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар | 4 | 118,464.0 | | | 4 | 118,464.0 | 4 | 118,464.0 | | | | |
| Дүн | **4** | **118,464.0** | | | **4** | **118,464.0** | **4** | **118,464.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газар | 2 | 35,162.8 | | | 2 | 35,162.8 | | | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **35,162.8** | | | **2** | **35,162.8** | | | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | 32 | - | - | - | 32 | - | - | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| -Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | | **1** | | | | **1** | | |



Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР